



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/35/НА-СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авч уу.



Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын ерөнхий аудитормын орлогч: Я.Самбууням
Утас: 51-261665 Цахим хаяг: Sambuuniam@audit.gov.mn
Санхүү, Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261683 Цахим хаяг: Naranchimegs@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нашагдорж
Утас: 280512 Цахим хаяг: natsagdorj@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 281729 Цахим хаяг: erdenezul@audit.gov.mn

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2024 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН**

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал	15
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	28
4. АУДИТЫН ТАЙЛАН	35
4.1 Ерөнхий зүйл	35
4.2 Материаллаг байдал	35
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	36
Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн зөрчил	36
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	37
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	37
Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил	37
Зөвлөмж	37
Түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн зөрчил	38
Зөвлөмж	38
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	39
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	39
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	41
5.2.1. Санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн залруулагдаагүй алдаа	42
Зөвлөмж	42
5.2.2. Санхүүгийн нэгтгэсэн тайланд илэрсэн санхүүгийн зөрчил	43
Албан шаардлага	43
Зөвлөмж	45
5.1.2 Түүвэрт хамрагдсан байгууллагад илэрсэн санхүүгийн зөрчил	47
1. Эрдэнэс УТП ХХК	47
Албан шаардлага	47
Зөвлөмж	47
2. Эрдэнэс Ашид ХХК	49
Зөвлөмж	49
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	51

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОХУ	Оросын Холбооны Улс
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮТП	Үйлдвэрлэл, технологийн парк
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ҮГА	Үндэсний геологийн алба
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бат зогсоо 3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-47-30
E-mail: info@audit.gov.mn

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙД Ц.ТУВААН ТАНАА**

2025.04.25 № 1624

талай _____ нийт № _____ -1

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 316,046.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2022 оны 459 дүгээр тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөнд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсний дагуу Тавантолгой төмөр зам ХХК нь зөвлөх үйлчилгээ авсан ч Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэж шийдвэр гаргаагүй, төслийн гүйцэтгэл болон хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй;
- Эрдэнэс Тавантолгой ХК нь Засгийн газрын шийдвэрүүдийн дагуу төрийн өмчит компаниудад 2018 оноос эхлэн 14 төсөл арга хэмжээнд 6,865,752.5 сая төгрөгийн зээл, санхүүжилт олгосноос тайлант онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 4 зээлийн

Z:\Waksan_Bichig\2025\0425 SHAG-06 D.O.

1525040605

25,775.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;

- Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах үйл ажиллагаандаа ашигладаггүй 8,716.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй нүүрс экспортлох гаалийн үзлэгийн зориулалттай 33,402 м.кв бетон хучилттай зам талбайг санхүүгийн тайланд тусгаж, хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй, Гашуунсухайт авто замыг дагасан боомтын дэд бүтцийн 28 нэр төрлийн 2,978.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг холбогдох байгууллагад хандаж зөвшөөрөл авахгүй нурааж, цаашид ашиглах боломжгүй болгосон;
- Тавантолгой төмөр зам ХХК 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг санал дүгнэлт авсан, Эрдэс баялгийн бирж ХХК, Эрдэнэс УТП ХХК, Эрдэнэс газ төслийн нэгжүүд санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй;
- Нэгтгэсэн санхүүгийн тайланд харьяа 9 байгууллага 19,110.2 сая төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- Харьяа 7 байгууллага худалдан авах ажиллагааны хууль, журам мөрдөөгүй нийт 14,769.2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, 14 дүгээр зүйлийн 14.2.10, 14.3, 54 дүгээр зүйлийн 54.2, 54.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.6, Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 45, 46, 47 дугаар тогтоол, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн Эрдэнэс таван толгой ХК-ийн 2022, 2023 оны төрийн өмчид хуваарилсан ногдол ашиг 3,305,196.8 сая төгрөгийг Эрдэнэс Монгол ХХК нь орлогоор хүлээн зөвшөөрч, авлагаар бүртгэсэн байна.

Эрдэнэс Монгол ХХК нь уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг өөрийн харьяаны Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, Монголросцветмет ТӨҮГ, Эрдэнэс Оюу Толгой ХХК, Эрдэнэс Таван толгой ХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас төрийн эзэмшилд ногдох 34 хувийн ногдол ашиг 495,742.2 сая төгрөгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлсэн байна.

Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг Төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн дагуу 2020 онд Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос төрд ногдох өгөөжийг арилжааны банкнуудад барьцаалан "Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн үүргийг төлөх" гэрээг байгуулж, нэг бүр нь 1.0 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 929,973 ширхэг 929,973.0 сая төгрөгийн Эрдэнэс-1 бонд гаргасан бөгөөд тайлант онд 80,000.0 сая төгрөгийг Монгол Банкнд төлсөн байна.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Чингис хаан банкнаас авах 65,503.2 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Үндэсний хөрөнгө оруулалтын банкнаас авах 42,358.7 сая төгрөгийн авлага барагдаагүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх, хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэлийг баталсан байна.

Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоолоор Гашуунсухайт-Ганц модны боомтын хил дамнасан гүүрийг хамтран барих төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийг боловсруулж, 16,299.5 сая төгрөгөөр магадласан байна.

Тус төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын үргэлжлэл бөгөөд өргөн царигийн 8.7 км, нарийн царигийн 10.8 км төмөр зам баригдаж, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай төмөр замаар холбогдох хоёр дахь гарц болж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам болгон өөрчлөн байгуулж, Цөмийн энергийн комиссын ажлын албыг түүний эрхлэх асуудлын хүрээний байгууллага болгосон байна.

Төрөөс геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж орд болохуйц хэтийн төлөвтэй газруудыг нээн илрүүлэх, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогын хүрээнд 2023-2024 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан хэлэлцэх 12 удаагийн хуралдаанаар 104 тайлан хэлэлцэж, элс хайрга, алт, нүүрс, жонш зэрэг голлох ашигт малтмалын 89 ордын нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэж, хүлээн авсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 2020-2024 онд 77,369.9 км.кв талбайд хэрэгжиж буй 20 геологийн судалгаа шинжилгээний ажлын төслийн үр дүнг хүлээн авч Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлж, Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 47.9 хувийг хамруулсан байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж, тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд сонгон шалгаруулалтыг 100 хувь цахимаар зохион байгуулж, 196,490 гектар бүхий 75 талбайг ялгаж, tender.gov.mn цахим системд ирүүлсэн 357 саналыг нээж, журмын шаардлагыг хангасан 109 оролцогчдын техникийн саналыг үнэлж, Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр 117,478 гектар бүхий хайгуулын 62 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Матад сум дахь Петро Матад компанийн газрын тосны Матад-ХХ талбайн Цэн тогоруу ордын нэгдүгээр цооногийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

олборлолтод шилжүүлж үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд тус ордын гадаргуугийн байгууламжийн угсралтын ажил, шингэн хагалбар болон олборлолтын туршилтын ажлууд хийгдсэнээр хоногт 200 баррель газрын тос олборлохоор төлөвлөж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслийн нэг болох Бүгд Найрамдах Франц Улсын төрийн өмчит Орано групптэй хамтарсан Зөөвч овоо ордыг хамтран ашиглах, уран олборлох "Хөрөнгө оруулалтын төслийн гэрээ"-г 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр үзэглэсэн байна.

Орчин үеийн дэвшилтэт техник, технологийн агаарын геофизикийн судалгаагаар дэлхийд тэргүүлэгч Австралийн Икскалибур Авиашн Австралиа компанитай хамтарсан нийт 30,268.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, Монгол орны 5 аймгийн 31 сумдын нутгийн 202,476.43 кв.км талбайг хамрах "Агаарын геофизик 2024" төслийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлыг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

		/мянган төгрөг/	
Код	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,159,750,579.8	10,328,521,642.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,925,484,176.0	1,845,361,661.0
33	АВЛАГА	1,454,391,070.1	1,939,632,728.1
34	УРЬДЧИЛГАА	4,080,882,293.9	4,592,843,256.6
35	БАРАА МАТЕРИАЛ	1,582,367,175.0	1,789,158,360.0
36	НӨӨЦИЙН БАРАА	23,175,390.4	23,175,390.4
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	93,450,474.6	138,350,246.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	29,028,200,878.8	32,951,529,074.0
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4,200,514,886.6	5,745,102,443.9
37300	Урт хугацаат зээл	4,200,514,886.6	5,745,102,443.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,827,685,992.1	27,206,426,630.1
39100	Газар	0.0	42,119,714.9
39200	Биет хөрөнгө	5,078,255,110.8	7,075,540,599.8
39300	Биет бус хөрөнгө	13,895,435,564.7	13,962,321,334.4
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	5,853,995,316.7	6,126,444,981.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	38,187,951,458.6	43,280,050,716.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,249,678,491.3	8,888,898,613.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,467,696,185.1	5,477,460,726.1
41200	Богино хугацаат зээлийн өглөг	731,229,154.2	431,943,302.6
41300	Өглөг	2,506,252,879.3	3,065,627,355.9
41400	Урьдчилж орсон орлого	2,230,214,151.6	1,979,890,067.6
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,781,982,306.2	3,411,437,887.3
42100	Урт хугацаат үнэт цаас	877,333,018.8	849,973,000.0
42200	Урт хугацаат зээл	1,904,649,287.4	2,561,464,887.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	29,938,272,967.3	34,391,152,103.1
51	Засгийн газрын хувь оролцоо	29,937,609,018.3	34,390,488,154.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	10,513,229.2	11,613,105.6
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,091,945,720.4	2,114,178,317.0
51103	Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	11,196,000,000.0	2,071,145,200.1
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	7,162,690,037.6	16,383,762,221.5
51200	Хуримтлагдсан үр дүн	8,880,869,406.5	13,076,677,989.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	595,590,624.6	733,111,320.4
52	Хяналтын бус хувь оролцоо	663,949.0	663,949.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	38,187,951,458.6	43,280,050,716.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,036,465,839.8	15,463,767,820.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	39,824,352.3	45,809,851.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	39,824,352.3	45,809,851.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,957,964,459.2	15,359,759,555.2
120	Нийтлэг татварын бус орлого	10,957,964,459.2	15,359,759,555.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,677,028.2	58,198,413.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,242,627,254.0	6,544,232,290.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,242,627,254.0	6,544,232,290.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,833,626,056.7	6,216,784,485.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,586,788.0	10,437,730.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	953,860.0	1,312,964.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,209.8	321,758.3
2104	Хангамж, бараа материалын зардал	470,006.7	534,312.9
2105	Нормативт зардал	0.0	1,113.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	580,919.8	546,635.8
2107	Томилолт, зочны зардал	723,108.7	539,283.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,820,859,329.4	6,200,810,262.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,298,834.4	2,480,424.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	409,001,197.2	327,447,804.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,793,838,585.8	8,919,535,530.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	24,822,343.2	5,729,852.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	50,724,780.2	33,447,456.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,767,936,148.8	8,891,817,925.8

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,651,673,193.2	-	24,651,673,193.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(267,037,900.1)	-	(267,037,900.1)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,384,635,293.1	-	24,384,635,293.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,703.1)	-	(1,703.1)

5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	1,202,605,606.9	-	1,202,605,606.9
8	Зарласан ногдол ашиг	(416,902,378.5)	-	(416,902,378.5)
9	Тайлант үеийн үр дүн	4,767,936,148.8	-	4,767,936,148.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,938,272,967.3	-	29,938,272,967.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,391,818,767.1	-	9,391,818,767.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	39,330,091,734.4	-	39,330,091,734.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	56,496,594.9	-	56,496,594.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	7,917,239.9	-	7,917,239.9
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	51,274,009.1	-	51,274,009.1
18	Зарласан ногдол ашиг	(4,792,912,736.2)	-	(4,792,912,736.2)
19	Тайлант үеийн үр дүн	8,891,817,925.8	-	8,891,817,925.8
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	43,544,684,767.8	-	43,544,684,767.8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	13,522,298,207.8	16,012,686,811.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	39,930,409.0	45,809,851.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	39,930,409.0	45,809,851.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	39,930,409.0	45,809,851.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,443,690,770.6	15,908,784,845.8
120	Нийтлэг татварын бус орлого	13,443,690,770.6	15,908,784,845.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	38,677,028.2	58,092,113.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,185,870,000.4	12,202,749,389.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,185,870,000.4	12,202,749,389.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,776,696,578.2	11,875,094,726.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	726,547,860.8	910,062,352.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	200,082,466.6	246,731,653.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	398,247,720.3	405,933,830.3
2104	Хангамж, бараа материалын зардал	3,183,755,127.3	3,349,399,363.6
2105	Нормативт зардал	1,040.0	4,889.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	770,875.9	579,599.3
2107	Томилолт, зочны зардал	701,131.8	564,864.9

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,266,025,045.8	6,961,192,229.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	565,309.6	625,945.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	409,173,422.2	327,654,662.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,336,428,207.4	3,809,937,421.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	132,131,125.3	583,825,076.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,509,472,804.8	2,420,379,452.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,509,472,804.8	2,420,379,452.1
2200	Дотоод эх үүсвэрээр	1,509,472,804.8	2,420,379,452.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,377,341,679.5)	(1,836,554,375.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(598,140,646.1)	(2,063,505,561.0)
14	Бусад эх үүсвэр	477,721,804.6	366,121,227.8
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,075,862,450.7	2,419,626,788.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,360,945,881.8	(80,122,515.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	564,538,294.2	1,925,484,176.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,925,484,176.0	1,845,361,661.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,794,331,000.00	59,234,706,734.14	(2,559,624,265.86)	95.9
УРСГАЛ ЗАРДАЛ	21,794,331,000.00	19,523,417,428.02	(2,270,913,571.98)	89.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,888,372,800.00	18,160,545,227.96	(727,827,572.04)	96.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,940,792,800.00	10,439,033,964.26	(501,758,835.74)	95.4
Үндсэн цалин	6,343,156,700.00	6,110,870,803.48	(232,285,896.52)	96.3
Нэмэгдэл	2,281,333,200.00	1,984,272,916.06	(297,060,283.94)	87.0
Унаа хоолны хөнгөлөлт	1,402,241,700.00	1,493,312,747.10	91,071,047.10	106.5
Урамшуулал	914,061,200.00	850,577,497.62	(63,483,702.38)	93.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,367,599,200.00	1,312,772,406.29	(54,826,793.71)	96.0
Тэтгэврийн даатгал	932,847,400.00	895,110,004.03	(37,737,395.97)	96.0
Тэтгэмжийн даатгал	108,688,100.00	105,408,236.02	(3,279,863.98)	97.0
ҮОМШӨ-ний даатгал	54,343,900.00	52,482,750.19	(1,861,149.81)	96.6
Ажилгүйдлийн даатгал	54,344,100.00	51,946,475.43	(2,397,624.57)	95.6
Эрүүл мэндийн даатгал	217,375,700.00	207,824,940.62	(9,550,759.38)	95.6



Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	290,870,600.00	181,538,166.40	(109,332,433.60)	62.4
Гэрэл, цахилгаан	85,331,900.00	48,191,078.32	(37,140,821.68)	56.5
Түлш, халаалт	97,386,500.00	48,509,728.85	(48,876,771.15)	49.8
Цэвэр, бохир ус	14,795,300.00	7,571,309.23	(7,223,990.77)	51.2
Байрны түрээс	93,356,900.00	77,266,050.00	(16,090,850.00)	82.8
Хангамж, бараа материалын зардал	485,609,400.00	479,206,326.22	(6,404,073.78)	98.7
Бичиг хэрэг	195,073,700.00	195,062,110.00	(11,590.00)	100.0
Тээвэр, шатахуун	74,172,200.00	74,163,900.00	(8,300.00)	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	141,103,200.00	136,694,367.22	(4,408,832.78)	96.9
Ном, хэвлэл	626,400.00	560,000.00	(66,400.00)	89.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,550,100.00	890,700.00	(659,400.00)	57.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	73,083,800.00	71,834,249.00	(1,249,551.00)	98.3
Нормативт зардал	4,905,000.00	4,889,000.00	(16,000.00)	99.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,905,000.00	4,889,000.00	(16,000.00)	99.7
Эд хогшил, урсгал засварын зардал	721,693,800.00	721,108,701.00	(585,099.00)	99.9
Багаж, техник, хэрэгсэл	153,480,000.00	155,008,330.00	1,528,330.00	101.0
Тавилга	39,620,000.00	39,080,000.00	(540,000.00)	98.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,063,500.00	15,012,870.00	(50,630.00)	99.7
Урсгал засвар	513,530,300.00	512,007,501.00	(1,522,799.00)	99.7
Томилолт, зочны зардал	459,947,400.00	457,865,843.51	(2,081,556.49)	99.5
Дотоод албан томилолт	459,947,400.00	457,865,843.51	(2,081,556.49)	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,314,580,100.00	4,263,255,193.26	(51,324,906.74)	98.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,987,677,800.00	3,952,032,034.51	(35,645,765.49)	99.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,120,000.00	5,000,000.00	(1,120,000.00)	81.7
Даатгалын үйлчилгээ	40,398,100.00	31,676,867.00	(8,721,233.00)	78.4
Тээврийн хэрэгслийн татвар	3,133,600.00	3,029,053.00	(104,547.00)	96.7
Тээврийн хэрэгслийн оношлогоо	757,500.00	644,675.00	(112,825.00)	85.1
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	214,517,000.00	209,749,463.75	(4,767,536.25)	97.8
Газрын төлбөр	59,763,100.00	59,720,100.00	(43,000.00)	99.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,213,000.00	1,403,000.00	(810,000.00)	63.4
Бараа үйлчилгээний бусад зардал	302,374,500.00	300,876,627.02	(1,497,872.98)	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	233,420,900.00	232,283,627.02	(1,137,272.98)	99.5

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	68,953,600.00	68,593,000.00	(360,600.00)	99.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,905,958,200.00	1,362,872,200.06	(1,543,085,999.94)	46.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	238,850,400.00	112,803,427.52	(126,046,972.48)	47.2
Засгийн газрын гадаад шилжүүлэг	238,850,400.00	112,803,427.52	(126,046,972.48)	47.2
Бусад урсгал шилжүүлэг	2,667,107,800.00	1,250,068,772.54	(1,417,039,027.46)	46.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	135,941,100.00	135,257,100.00	(684,000.00)	99.5
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,445,371,400.00	1,029,016,372.54	(1,416,355,027.46)	42.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,423,400.00	52,423,400.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,371,900.00	33,371,900.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,000,000,000.00	39,711,289,306.12	(288,710,693.88)	99.3
Бусад хөрөнгө	40,000,000,000.00	39,711,289,306.12	(288,710,693.88)	99.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,794,331,000.00	61,631,293,178.12	(263,037,821.88)	99.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,634,171,300.00	56,485,509,581.74	(1,148,661,718.26)	98.0
Улсын төсвөөс санхүүжих	57,634,171,300.00	56,485,509,581.74	(1,148,661,718.26)	98.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,160,159,700.00	5,046,783,596.38	886,623,896.38	121.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,160,159,700.00	5,018,276,796.38	858,117,096.38	120.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	27,506,800.00	27,506,800.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	-	100.0
Төсвийн байгууллага	4	4	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	365	355	(10)	97.3
Удирдах ажилтан	37	37	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	285	275	(10)	96.5
Үйлчлэх ажилтан	43	43	-	100.0



2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөв лөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		833,129,280.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ		833,129,280.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		507,486,945.63
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		136,649,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		80,402,900.00
210602	Тавилга		39,600,000.00
210604	Урсгал засвар		16,646,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		330,905,545.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		330,905,545.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		39,932,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		39,932,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		325,642,335.13
2132	Бусад урсгал шилжүүлэг		303,139,898.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		303,139,898.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		22,502,437.13
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		22,502,437.13
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		833,129,280.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		833,129,280.76
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		307,673,109.76
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		31,385,096.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		200,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		294,071,075.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг МУЗГ-ын 2024 оны 30 дугаар тогтоолоор баталж, үйл ажиллагааны чиглэл, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлсон байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь эрхэм зорилгоо "аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрдэс, түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, газрын тосны боловсруулах үйлдвэрийг байгуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэхэд оршино" гэж тодорхойлсон байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь үйл ажиллагааны 9 стратеги, гол зорилтын хүрээнд 56 чиглэлийн үй ажиллагааг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд /хуучин нэрээр/-ын эрхлэх асуудлаар тусгасан 3 зорилгын хүрээнд 15 арга хэмжээний хэрэгжилтийг 72.7 хувиар тайлагнасан байна.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийн эхний үе шатанд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нийт 3 зорилтын 13 арга хэмжээ, хөгжлийн төслийн жагсаалтад орсон орсон 13 төсөл, чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтад орсон 4 хуулийн төслийн хэрэгжилтийг хангах, нийт 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээс гүйцэтгэл 59.6 хувьтай тайлагнасан байна.

Тайлант онд 8 зорилтын хүрээнд 142 арга хэмжээг хэрэгжүүлэхээр үр дүнгийн гүйцэтгэлийг төлөвлөн, гүйцэтгэлийг 87.2 хувьтай тайлагнасан байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зэрэг холбогдох хууль, бодлого чиглэл, дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;

- Цөмийн энергийн тухай хууль;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны 4 сарын 01-ний өдрийн "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А52 дугаар тушаал;
- Засгийн газрын 2024 оны "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 6 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2024 оны "Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр" 30 дугаар тогтоол.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь дараах үндсэн үүрэг, чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, төсвийн санхүүжилт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах;
- Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хөтөлбөр төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнг дүгнэх, дүгнэлт зөвлөмж гаргах, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөр, гэрээний хэрэгжилт болон иргэд, байгууллагын мэдээлэл, өргөдөл гомдлын мөрөөр дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний яам, төсөвт байгууллагууд, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж, зохих арга хэмжээг авах, зөвлөмж гаргах, улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ, хийж, дүгнэлт өгч, зөвлөмж гаргах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авахад тайлант онд харьяа төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдэд хяналт шалгалт хэрэгжүүлээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгүүдтэй холбоотой дараах асуудлууд байгааг, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх, шинэчлэхэд анхаарах шаардлагатай байна. Тухайлбал:

- Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК, Тавантолгой төмөр зам ХХК, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн шинэчлээгүй, үйл ажиллагааны зарим онцлогт тохирсон зохицуулалт тусгаагүй;
- Багануур ХК, Мон-Атом ТӨХХК нь Эрдэнэс Монгол ХХК-аас гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд энэ нь тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй;
- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч зарим данснуудын бодлогод холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх шаардлага үүссэн;
- АҮЭБЯ нь төсвийн хүрээнд гүйцэтгүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хүлээн зөвшөөрч бүртгэх, үр дүнг үнэлэх, данснаас хасах талаарх зохицуулалт тусгаагүй;
- АМГТГ нь улсын төсвийн болон өөрийн орлого бүрдүүлэлтийг мөнгөн сууриар хөтлөхөөр тусгасан, сургалтын урамшууллын хөрөнгийн зарцуулалтын бүртгэлийн бодлого боловсруулж мөрдөөгүй;
- ҮГА нь аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд үүнд геологийн судалгааны ажлын техник хяналтын зардлын бүртгэлд баримтлах бодлогыг тусгаагүй;
- Цөмийн энергийн комисс нь 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн МУЗГ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Аж үйлдвэр эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болсон тул салбарын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөх шаардлага үүссэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн боловч санхүүгийн тайлангийн тодруулгыг иж бүрэн бэлтгээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд тайлант хугацаанд гарсан онцлог, материаллаг ажил гүйлгээ, өөрчлөлт зэргийг тодорхой байдлаар тэмдэглэж бичиж хэвшээгүй байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,092,099.3 сая төгрөгөөр буюу 13.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,925,484.2	1,845,361.6	(80,122.6)
Авлага	1,454,391.0	1,939,632.6	485,241.6
Урьдчилгаа	4,080,882.3	4,592,843.3	511,961.0
Бараа материал	1,582,367.2	1,789,158.4	206,791.2
Нөөцийн бараа	23,175.4	23,175.4	-
Бусад эргэлтийн хөрөнгө	93,450.5	138,350.2	44,899.7
Урт хугацаат хөрөнгө оруулалт /Урт хугацаат зээл/	4,200,514.9	5,745,102.4	1,544,587.5
Үндсэн хөрөнгө	24,827,686.0	27,206,426.6	2,378,740.6
Нийт хөрөнгө	38,187,951.5	43,280,050.5	5,092,099.0
Богино хугацаат өр төлбөр	5,467,696.2	5,477,460.7	9,764.5
Урт хугацаат өр төлбөр	2,781,982.3	3,411,437.8	629,455.5
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	29,938,273.0	34,391,152.0	4,452,879.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	38,187,951.5	43,280,050.5	5,092,099.0

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан засгийн газрын хувь оролцоо, үндсэн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, мөнгөн хөрөнгө, урт хугацаат өр төлбөр, урьдчилгаа, авлага зэрэг данснууд байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,845,361.6 сая төгрөг болж, 80,122.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт +, Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	89.9	166.9	77.0
Төгрөг	71.2	142.9	71.7
Гадаад валют	18.7	24.0	5.3
Банканд байгаа бэлэн мөнгө	1,914,795.3	1,828,194.7	(86,600.6)
Төгрөг	1,024,141.1	1,761,346.9	737,205.8
Төрийн сангийн харилцах	3,707.1	18,164.8	14,457.7
Арилжааны банк дахь харилцах	1,020,434.0	1,743,182.1	722,748.1
Гадаад валют	890,654.2	66,847.8	(823,806.4)
Арилжааны банк дахь харилцах	890,654.2	66,847.8	(823,806.4)
Хадгаламж	10,599.0	17,000.0	6,401.0
Дүн	1,925,484.2	1,845,361.6	(80,122.6)

Эх сурвалж: АҮЭБС-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн бууралтад дараах ажил, гүйлгээнүүд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал:

- Эрдэнэс Тавантолгой ХК нь Үндэсний баялгийн санд 2024 оны ногдол ашгаас 200,000.0 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн, Хөрөнгийн биржийн дансанд

гэрээний хэрэгжилт хангагдсан ч өөрийн дансанд шилжүүлэн аваагүй 588,906.6 сая төгрөгийн барьцаа байршуулсан, толгой компанийн нэхэмжилсэн менежментийн төлбөрт 86,660.2 сая төгрөгийг шилжүүлсэн зэргээс мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 133.1 сая төгрөгөөр буюу 8.5 хувиар буурсан;

- Тавантолгой төмөр зам ХХК-ийн мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 30,545.4 сая төгрөгөөр буурсан нь арилжааны банк дахь хугацаатай хадгаламж нэмж байршуулсантай;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 10,701.5 сая төгрөгөөр буурсан нь арилжааны банк дахь ам.долларын 11 харилцах дансны үлдэгдлээс 10,244.0 сая төгрөг, төгрөгийн 18 харилцах дансны үлдэгдлээс 6,860.2 сая төгрөг, кассын үлдэгдлээс 1.7 сая төгрөгийг тус тус зарцуулж, банк дахь хугацаатай хадгаламж 6,401.0 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Эрдэнэс оюу толгой ХХК-ийн мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,675.9 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 5,772.9 сая төгрөгийн оффисын барилга худалдан авсан.

Мөнгөн хөрөнгийн дансанд кассад бэлнээр 15 байгууллагын 89.9 сая төгрөг, арилжааны банканд 27 байгууллагын 1,828,194.7 сая төгрөг, үүнээс Төрийн сангийн хөрөнгө оруулалт, геологи судалгааны ажил, орлогын 3 дансанд 18,164.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөн хадгаламжийн данс дахь 17,000.0 сая төгрөгийн үлдэгдэл нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Капитрон банканд байршуулсан мөнгөн хөрөнгө байна.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2017 онд Чингис хаан банканд байршуулсан 53,266.3 сая төгрөгийг албадан гүйцэтгэхээр шүүхийн шийдвэр гарсан ч хэрэгжээгүй, мөн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Үндэсний хөрөнгө оруулалтын банк дахь харилцах дансны үлдэгдэл 42,358.7 сая төгрөг төлөгдөөгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс үндсэн чиг үүрэгт хамааралгүй, нийгмийн шинж чанар бүхий арга хэмжээнд 4,141.0 сая төгрөгийг зарцуулсан /Монголросцветмет ТӨҮГ 3,240.1 сая төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК 671.9 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 229.0 сая төгрөг/;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 306.2 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан /Эрдэнэс Тавантолгой ХК 261.2 сая төгрөг, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК 25.6 сая төгрөг, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 17.5 сая төгрөг гэх мэт/;
- Албан томилолт, шатахууны зардлыг батлагдсан норм, нормативаас илүү бодож олгосон 76.9 сая төгрөг /Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 69.9 сая төгрөг, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ 3.8 сая төгрөг, Эрдэнэс оюу толгой ХХК 2.1 сая төгрөг гэх мэт/;
- Арвилан хэмнэлтгүй, зориулалт бусаар 110.6 сая төгрөгийг зарцуулсан /УГА 44.1 сая төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 42.1 сая төгрөг, АУЭБЯ 21.7 сая төгрөг гэх мэт/;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь төлөөлөгчийн газруудад 1,682.8 сая төгрөгийг зарцуулсан ч үйлдвэрт ашиг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулсан эсэх, үр ашиг авчрах гэрээ, хэлцэл хийсэн эсэх, цаашид одоогийн чиг үүргээр ажиллуулах хэрэгцээ шаардлагатай эсэхэд дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргаагүй;
- Цалин, үр дүнгийн урамшууллын зохих шийдвэргүйгээр болон илүү бодож нийт 853.6 сая төгрөгийг зарцуулсан /Тавантолгой төмөр зам ХХК 304.8 сая төгрөг, Монголросцветмет ТӨҮГ 292.7 сая төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК 237.0 сая төгрөг, АУЭБЯ 5.8 сая төгрөг, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 5.1 сая төгрөг, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК 2.2 сая төгрөг гэх мэт/.

3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 1,939,632.6 сая төгрөг болж, 485,241.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	14.9	76.5	61.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	11.1	11.1
Дансны авлага /ТӨҮГ/	624,092.1	832,730.9	208,638.8
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	233,509.0	221,415.1	(12,093.9)
Бусад авлага	596,775.0	885,399.0	288,624.0
Дүн	1,454,391.0	1,939,632.6	485,241.6

Эх сурвалж: АҮЗБС-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн авлагын дансны үлдэгдэл 978,149.7 сая төгрөг болж өмнөх оноос 344,579.9 сая төгрөгөөр буюу 54.4 хувиар нэмэгдсэн нь борлуулалтын авлага, холбоотой талаас авах авлага нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн;
- Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн авлагын үлдэгдэл 629,210.6 сая төгрөг болж, 72,821.5 сая төгрөгөөр өссөн нь 89 борлуулалтын гэрээний дагуу Монголын хөрөнгийн биржид 27,719.4 сая төгрөгийн дэнчин байршуулсан, 45,596.0 сая төгрөгийн үлдэгдлийг авлага дансанд залруулан бүртгэсэн;
- Тавантолгой төмөр зам ХХК-ийн авлага дансны үлдэгдэл 224,319.5 сая төгрөг болж, өмнөх оноос 36,636.3 сая төгрөгөөр өссөн нь дансны авлага 9,505.8 сая төгрөг, НӨАТ-ын авлага 20,644.0 сая төгрөг, бусад авлага 3,281.5 сая төгрөгөөр өссөн;
- Эрдэнэс Монгол ХХК-ийн авлага дансны үлдэгдэл 3,381,163.5 сая төгрөг болж, өмнөх оноос 3,323,585.8 сая төгрөгөөр өссөн. Энэ нь тайлант онд Эрдэнэс Тавантолгой ХК-аас 2022, 2023 оны ногдол ашгийн 3,305,196.8 сая төгрөгийн авлага, охин, хараат компаниудад олгосон зээлийн санхүүжилтийн авлага 31,453.0 сая төгрөгөөр, хүүгийн авлага 577.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- Эрдэнэс алт ресурс ХХК-ийн дансны авлагын үлдэгдэл 25,048.1 сая төгрөг болж, 24,372.4 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлого 3 дахин нэмэгдэн гадаад худалдан авагчидтай холбоотой авлага 22,675.7 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Монголросцветмет ТӨҮГ-ын авлагын дансны үлдэгдэл 25,146.9 сая төгрөг болж, өмнөх оноос 10,178.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант жилийн борлуулалтыг Монголын хөрөнгийн биржээр борлуулж эхэлсэнтэй холбоотойгоор 12,059.3 сая төгрөгийн дэнчин байршуулсан, 4,587.6 сая төгрөгийн байгууллагаас авах авлага, 8,805.3 сая төгрөгийн татварын авлага үүссэн;
- Шивээ Овоо ХК-ийн авлагын дансны үлдэгдэл 11,284.1 сая төгрөгт болж өмнөх оноос 7,248.0 сая төгрөгөөр өссөн нь нүүрсний үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор харилцагчдаас авах авлага нэмэгдсэн.

Авлагын дансны 1,939,632.6 сая төгрөгийн үлдэгдлийн 50.0 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 32.2 хувийг Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК, 11.5 хувийг Тавантолгой төмөр зам ХХК, 1.4 хувийг Эрдэнэс алт ресурс ХХК, 1.3 хувийг Монголросцветмет ТӨҮГ, 1.0 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, 2.6 хувийг бусад байгууллагууд тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

- Эрдэнэс Монгол ХХК нь өөрийн 10 охин болон хараат компаниудад 2016 оноос эхлэн 11-14 хувийн хүүтэй зээлийн санхүүжилт олгон, эргэн төлөлт хийгдээгүйгээс 164,932.4 зээл авлага хуримтлагдсан, зээл олгохдоо эргэн төлөх бололцоог нь үнэлээгүй, эрсдэлийн үнэлгээний дүн шинжилгээ хийгээгүй нь цаашид эдгээр компаниудыг үйл ажиллагаагаа сайжруулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх, зардлаа хэмнэх идэвх оролцоог сулруулах эрсдэлийг бий болгосон;
- Эрдэнэс Тавантолгой ХК нь төрийн өмчит компаниуд олгосон зээл, санхүүжилтээс тайлант онд эргэн төлөгдөх 25,775.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, хугацаа хэтрүүлсэн;
- Мөн тайлант онд Шивээ Овоо ХК-д олгосон зээлийн санхүүжилттэй холбоотой 2,211.9 сая төгрөгийн хүүгийн авлага үүссэн бөгөөд зээлийн санхүүжилтийн гэрээнд зээлийн хүү төлөгдөх хуваарьгүй, хэзээ төлөгдөх нь тодорхойгүй;
- Харьяа 5 байгууллага насжилт ихтэй 3,916.6 төгрөгийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй /Тавантолгой төмөр зам ХХК 1,222.0 сая төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК 1,215.3 сая төгрөг, Монголросцветмет ТӨҮГ 443.3 сая төгрөг, Эрдэс баялгийн бирж ХХК 477.4 сая төгрөг/;
- Харьяа 7 байгууллага нийт 16,643.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК 14,841.6 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 3,478.2 сая төгрөг, Тавантолгой төмөр зам ХХК 768.0 сая төгрөг, Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ 445.9 сая төгрөг, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 336.9, Монголросцветмет ТӨҮГ 149.0 сая төгрөг, Шивээ Овоо ХК 102.5 сая төгрөг, Эрдэнэт Медикал эмнэлэг ХХК 166.3 сая төгрөг/.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 4,592,843.3 сая төгрөг болж, 511,961.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт +, Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	3,967,135.0	4,586,611.1	619,476.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	107,873.4	6,123.1	(101,750.3)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	5,834.4	64.2	(5,770.2)
Томилолтын урьдчилгаа	39.5	44.9	5.4
Дүн	4,080,882.3	4,592,843.3	511,961.0

Эх сурвалж: АҮЗБС-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд дараах байгууллагуудад материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн урьдчилгаа дансны үлдэгдэл 2,821,204.1 сая төгрөг болж, өмнөх оноос 666,199.1 сая төгрөгөөр буюу 30.9 хувиар нэмэгдсэн нь Үндэсний баялгийн санд 2024 оны ногдол ашиг 200,000.0 сая төгрөгийг, Үнэт цаасны хадгаламжийн төвд 360,916.3 сая төгрөгийн ногдол

- ашиг, тоног төхөөрөмжийн урьдчилгаанд 136,638.8 сая төгрөг, татварт 47,451.2 сая төгрөгийг урьдчилан шилжүүлсэн нь голлон нөлөөлсөн;
- Тавантолгой төмөр зам ХХК-ийн урьдчилгаа дансны үлдэгдэл 1,515,035.3 сая төгрөг болж, өмнөх оноос 36,636.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрдэнэс Тавантолгой ХК-аас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд нүүрсээр 78,251.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон, ТНАЛТ төслийн гүйцэтгэлийг үндэслэн 14,167.6 сая төгрөгийн өглөгийг хаасан, Гашуунсухайт төслийн гүйцэтгэлийн дүнгээс тооцсон НӨАТ-ын авлагын дүн 23,833.4 сая төгрөгөөр буурсан, урьдчилгаа төлбөрөөс захиалагчийн хяналт хийхтэй холбоотой 3,339.8 сая төгрөгийг урьдчилгааг дуусаагүй үйлдвэрлэл буюу бусад эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэсэн зэрэг нь нөлөөлсөн;
 - Эрдэнэс Монгол ХХК нь урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 17,322.2 сая төгрөг болж, 15,424.5 сая төгрөгөөр өссөн нь Гашуунсухайт-Тавантолгой чиглэлийн хүнд даацын тусгай зориулалтын 239 км автозамын засвар, арчилгаа хийлгэхээр 7 харилцагч байгууллагад 11,014.4 сая төгрөг, төслийн нэгжүүдийн үйл ажиллагаанд 5,282.8 сая төгрөгийн урьдчилгааг тус тус шилжүүлсэн;
 - Эрдэнэс оюу толгой ХХК-ийн урьдчилгаа дансны үлдэгдэл 5,774.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь түрээсийн төлбөр, хөрөнгө нийлүүлэх урьдчилгаа төлбөр төлсөн;
 - Эрчис ойл ХХК-ийн урьдчилгаа дансны үлдэгдэл 12,338.3 сая төгрөгт болж 4,011.5 сая төгрөгөөр өссөн нь ОХУ-ын РН-Аэро ХХН-тэй байгуулсан "Агаарын хөлгийн ТС-1 шатахуун худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу төлбөрөө урьдчилан шилжүүлсэн.

Урьдчилгаа дансны 4,592,843.3 сая төгрөгийн үлдэгдлийн 61.4 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 33.0 хувийг Тавантолгой төмөр зам ХХК, 1.8 хувийг УГА, 1.2 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, 1.0 хувийг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК, 1.6 хувийг бусад байгууллагууд тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Шивээ Овоо ХК-ийн урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай 326.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- АҮЭБЯ нь жилийн эцэст нийт 94.0 сая төгрөгийг анхан шатны баримт, тооцоо судалгаагүйгээр харилцагч байгууллагууд руу урьдчилан шилжүүлсэн.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 1,789,158.4 сая төгрөг болж, 206,791.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	614,754.9	578,443.7	(36,311.2)
Тусгай зориулалттай материал	614,725.3	578,413.6	(36,311.6)
Эм боох материал	29.6	30.1	0.5
Дуусаагүй үйлдвэрлэл	16,399.5	26,708.2	10,308.8
Бэлэн бүтээгдэхүүн	714,323.1	912,137.2	197,814.1
Хангамжийн материал	236,889.8	271,869.2	34,979.5

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бичиг хэргийн материал	174.6	181.2	6.5
Аж ахуйн материал	1,278.7	2,517.2	1,238.5
Сэлбэг хэрэгсэл	99,040.6	110,111.3	11,070.7
Түлш, шатах тослох материал	8,109.6	8,354.5	244.9
Барилгын засварын материал	394.9	373.4	(21.5)
Хүнсний материал	1.3	369.2	367.9
Бусад хангамжийн материал	127,890.0	149,962.4	22,072.4
Дүн	1,582,367.2	1,789,158.4	206,791.2

Эх сурвалж: АҮЭБС-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бэлэн бүтээгдэхүүн 197,814.1 сая төгрөгөөр, хангамжийн материал 34,979.5 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 11,070.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материалын үлдэгдлийн өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт

- Эрдэнэс Тавантолгой ХК "Сая тонн-сая мод" хөтөлбөрийн хүрээнд тайлант онд 3,558.7 сая төгрөгийн 2.5 сая мод тарьсныг шууд зардлаар бүртгэсэн нь төрийн өмч хөрөнгөнд тавих хяналт алдагдах, хөтөлбөрийн үр дүнг тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэн;
- Эрдэнэс Тавантолгой ХК ажлын тусгай хувцас, хамгаалах тусгай хэрэгслийн хөдөлгөөн, зарцуулалтад нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул, өөрсдийн саналаар болон ажлын хариуцлагаас шалтгаалан ажлаас гарсан ажилчдын хувцас, хэрэгслийн тооцоо хийх зохицуулалт байхгүй;
- Тавантолгой төмөр зам ХХК тусгай зориулалтын машин механизмын шатахуун зарцуулалтын нормыг тусгайлсан журмаар зохицуулаагүйгээс шатахууны зардлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй;
- Багануур ХК насжилт өндөртэй бараа материалын нөөц үүссэн байгаа зөрчлийг арилгахаар хүргүүлсэн өмнөх оны албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд худалдан авч зарцуулаагүй 49 нэр төрлийн 587.7 сая төгрөгийн барааны нөөц хадгалагдаж байна;
- Багануур ХК тайлант онд 4 төрлийн барааг их хэмжээгээр худалдан авч, оны эцэст 151,640 ширхэг 217.7 сая төгрөгийн барааны үлдэгдэлтэй;
- Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК тавантолгойн хүдрийн уурхайн бараа материалаас "Ачигчийн сэлбэг" нэртэй сэлбэг материалыг түүвэрлэн авч хяналтын тооллого явуулахад 596 ширхэг, 218.9 сая төгрөгийн бараа материал илүү, 648 ширхэг 124.8 сая төгрөгийн бараа материал дутуу байна. Тус байгууллагын өмнөх тооллогын комиссууд хөрөнгийг нэг бүрчлэн тоолоогүй, чанар байдлыг тодорхойлоогүй, тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй;
- Монголросцветмет ТӨҮГ-ын Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрийн шатахууны үлдэгдэлд биет тест хэрэгжүүлэхэд 21.882 кг буюу 73.7 сая төгрөгийн шатахуун илүү үлдэгдэлтэй;
- Шивээ Овоо ХК нь техникийн шинэчлэлтэй холбоотойгоор ашиглалтгүй болсон 463.8 сая төгрөгийн сэлбэг агуулахад хадгалагдаж байна.

3.4.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 5,745,102.4 сая төгрөг болж, 1,544,587.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Урт хугацаат хөрөнгө оруулалт

/сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	2,390.4	1,572,474.0	1,570,083.6
Урт хугацаат хөрөнгө оруулалт	4,198,124.5	4,172,628.4	(25,496.1)
Дүн	4,200,514.9	5,745,102.4	1,544,587.5

Эх сурвалж: АҮЭБС-ын 2024 оны санхүүгийн нэвтэрсэн тайлан

Эрдэнэс Монгол ХХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалт 2,305.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 5 дугаар тогтоолын дагуу Эрдэнэс Ашид ХХК-ийн нийт хувьцааны 66 хувь буюу 660 ширхэг хувьцааг худалдан авч, 2,455.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж нэгдлийн бүрэлдэхүүнд ажиллуулахаар шийдвэрлэсэн. Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 8 дугаар тогтоолоор 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай Эрдэнэс Стил ХХК болон 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай Эрдэнэс ассет менежмент ХХК-иудыг татан буулгах шийдвэр гаргасан байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 5,745,102.4 сая төгрөгийн дансны үлдэгдэлд 50.8 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 47.7 хувийг Эрдэнэс Оюу Толгой ХХК, 1.1 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, бусад 4 байгууллага 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

- Мон-Атом ТӨХХК өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар компанийн өмчид бүртгэлтэй Төв-Азийн-Уран ХХК-ийн хувьцааны 21.0 хувийн өмчлөлтэй холбоотой асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэж, компанийн өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл цэвэр дүнгээр 27,206,426.6 сая төгрөг болж, 2,378,740.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	-	42,119.7	42,119.7
Барилга, байгууламж, орон сууц	1,406,241.8	1,569,541.9	163,300.1
Авто-тээврийн хэрэгсэл	490,503.7	1,096,805.7	606,302.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,167,242.3	1,378,255.5	211,013.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	32,278.9	31,847.5	(431.4)
Зам, гүүрний байгууламж	117,252.3	102,372.3	(14,880.0)
Бусад үндсэн хөрөнгө	146,713.4	187,490.3	40,776.9
Дуусаагүй барилга, байгууламж	1,718,021.0	2,709,225.6	991,204.6
Ном	1.7	1.7	0.0
Биет бус хөрөнгө	13,895,435.6	13,962,321.3	66,885.8
Програм хангамж	13,330.2	16,683.4	3,353.2
Бусад биет бус хөрөнгө	13,882,105.4	13,945,637.9	63,532.5
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	5,853,995.3	6,126,445.0	272,449.7
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/	139,067.5	139,934.5	867.0


Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	249,399.3	128,561.6	(120,837.7)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө /ТӨҮГ/	1,202.7	1,915.0	712.4
Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + бусад	5,464,325.9	5,856,033.8	391,707.9
Дүн	24,827,686.0	27,206,426.6	2,378,740.6

Эх сурвалж: АҮЭБС-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад тайлант онд нийт 271,070.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 128,580.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авч, 7,174.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасаж, 609,697.0 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тавантолгой төмөр зам ХХК нь МУЗГ-ын 2022 оны 459 дүгээр тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөнд хөндлөнгийн аудит хийлгэсэн ч ТУЗ-өөр хэлэлцэж, шийдвэр гаргаагүй, төслийн гүйцэтгэл болон хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй;
- Компанийн өөрийн эзэмшлийн бус газар дээр байрлах, үйл ажиллагаандаа ашиглагддаггүй 8,716.0 сая төгрөгийн үлдэх өртөгтэй нүүрс экспортлох гаалийн үзлэгийн зориулалттай 33,402 м2 бетон хучилттай үзлэгийн зам талбайг санхүүгийн тайланд тусгаж хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй, мөн Гашуунсухайт авто замыг дагасан боомтын дэд бүтцийн 28 нэр төрлийн 2,978.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг холбогдох байгууллагад хандаж зөвшөөрөл авахгүй нурааж, цаашид ашиглах боломжгүй болсон;
- Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь Газрын тос боловсруулах үйлдвэрийн (ЕРС 01) багц ажлын хүрээнд барилгын ерөнхий гүйцэтгэгчээс хүлээлгэн өгөх 274 нэр төрлийн бууршгүй нөөцийн хөрөнгийг хүлээлцээгүй, нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй;
- Тавантолгой төмөр зам ХХК газар эзэмших эрхүүдийг нийт дүнгээр бүртгэснийг талбар нэгж бүрээр бүртгэх өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хувьцаа эзэмшигчээс хөрөнгө оруулсан 7,400.6 сая төгрөгийн өртөг бүхий газар эзэмших эрх хүчингүй болж, улсын бүртгэлийн лавлагаагаар баталгаажаагүй;
- Тавантолгой төмөр зам ХХК нь өөрийн хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулж 2,800.0 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан;
- ҮГА нь Геологийн баримтын төв архивын тооллогоор 15 тайлангийн ном, дэвтэр, 89 тайлангийн хавсралт зургууд тоологдоогүй, дутагдсан бөгөөд тооллогын комиссоос 1994 оноос эхлэн зарим нь тоологдоогүй байсан гэсэн тэмдэглэл хөтөлсөн байна. Тайлант онд дээрх дутагдсан хөрөнгийг шийдвэрлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй;
- Тайлант хугацаанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, актлах талаар эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй /Багануур ХК 19,198.0 сая төгрөг, АҮЭБЯ 711.8 сая төгрөг, АМГТГ 8,963.0 сая төгрөг, ҮГА 1,247.7 сая төгрөг, Шивээ Овоо ХК 51,384.8 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 546,582.1 сая төгрөг/;
- Мон-Атом ТӨХХК үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоогоогүй;
- АМГТГ, Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг КОЙКА-тай хамтран "Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах хүрээнд эрчим хүчний эх үүсвэрийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх" төслийн хүрээнд Уул уурхай, газрын тосны төв лабораторид 6.8 тэрбум төгрөгийн



их засвар хийж, тоног төхөөрөмж нийлүүлснийг хүлээн авсан боловч бүртгэлд тусгаагүй, бүртгэлд тусгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй;

- АМГТГ газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийг хийж буй 8 хуулийн этгээдтэй байгуулсан эрлийн ажил гүйцэтгэх гэрээнд газрын тосны газраас томилогдсон мэргэжилтний ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах 1 ширхэг автомашин /жиип ангиллын туулах чадвар сайтай, шинэ, дизель хөдөлгүүртэй/-ыг газрын тосны газарт буцалтгүйгээр өгөх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, тус гэрээний заалтын хэрэгжилтийг хуульд нийцүүлэх, гэрээний үүргийг хангах талаар зохих арга хэмжээг аваагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 8,888,898.6 сая төгрөг болж, 639,220.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,467,696.2	5,477,460.7	9,764.5
Богино хугацаат зээлийн өглөг	731,229.2	431,943.3	(299,285.9)
Өглөг	2,506,252.9	3,065,627.4	559,374.5
Урьдчилж орсон орлого	2,230,214.2	1,979,890.1	(250,324.1)
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,781,982.3	3,411,437.8	629,455.5
Урт хугацаат үнэт цаас	877,333.0	849,973.0	(27,360.0)
Урт хугацаат зээл	1,904,649.3	2,561,464.8	656,815.5
Дүн	8,249,678.5	8,888,898.5	639,220.0

Эх сурвалж: АҮЗБС-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат өр төлбөр 629,455.5 сая төгрөгөөр өссөн нь нийт өр төлбөрийн үлдэгдэл нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 22.7 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 21.2 хувийг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК, 20.0 хувийг Эрдэнэс Алт ресурс ХХК, 20.0 хувийг Эрдэнэс Монгол ХХК, 7.4 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, 4.2 хувийг Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК, 2.5 хувийг Шивээ Овоо ХК, 1.1 хувийг Багануур ХК-ийн үлдэгдэл, 0.9 хувийг бусад байгууллагын үлдэгдэл эзэлж байна.

Урьдчилж орсон орлого дансанд 13 байгууллагын 1,979,890.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулалтын орлогыг урьдчилан авч байршуулсан бөгөөд 67.2 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 12.3 хувийг Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК, 11.4 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, 5.4 хувийг Монголросцветмет ТӨҮГ, 1.4 хувийг Эрчис ойл ХХК, 1.1 хувийг Эрдэнэс Алт ресурс ХХК, 1.1 хувийг Тавантолгой төмөр зам ХХК, 0.1 хувийг бусад байгууллагын үлдэгдэл тус тус эзэлж байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 5,477,460.7 сая төгрөгийн 36.1 хувийг урьдчилж орсон орлого, 22.2 хувийг дансны өглөг /ТӨҮГ/, 21.7 хувийг татвар байгууллагад төлөх, 9.5 хувийг байгууллагад төлөх өглөг, 7.9 хувийг богино хугацаат зээлийн өглөг, 1.1 хувийг ажилчидтай холбогдсон өглөг, 1.5 хувийг ногдол ашгийн, зээлийн хүүгийн, хувийг хувь хүмүүс, НДШ, бусад тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч байгууллагуудтай өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК 192.9 сая төгрөг, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 231.3 сая төгрөг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 822.4 сая төгрөг, Эрдэнэт Медикал эмнэлэг ХХК 74.6 сая төгрөг/;
- Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн дансанд бүртгэлийн алдаанаас үүссэн 274 харилцагчийн 456.3 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй байгаагаас тэг төгрөгийн үлдэгдэлтэй тооцоогүй гэж тооцоо нийлсэн 96 харилцагчийн 299.1 сая төгрөгийн, НӨАТ-ын буруу бүртгэлээс зөрүү 12.7 сая төгрөгийн, Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болж ажлаас гарсан 59 ажилтанд төлөх 18.7 сая төгрөгийн зэрэг бодитой бус өглөгийг барагдуулах, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэн данснаас хасах зэрэг арга хэмжээг аваагүй;
- Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК-ийн нийт хөрөнгийн 76.4 хувь нь өр төлбөрөөр санхүүжсэн, тайлант онд урьдчилж орсон орлогоос бусад өр төлбөрийн дүн 20,427.9 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Эрдэнэс Оюу толгой ХХК Үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор толгой компани буюу Эрдэнэс Монгол ХХК-иас 2012-2021 оны хугацаанд авсан үндсэн зээл, хуримтлагдсан зээлийн хүүгийн төлбөрт 12,022.2 сая төгрөгийн өртэй байгаа нь тус компанийн төлбөрийн чадварыг илэрхийлэх санхүүгийн үзүүлэлтүүдийн зохистой харьцаа алдагдсан;
- Багануур ХК, толгой компанид өгөх Менежментийн төлбөрт 21,253.6 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөр бүртгэлтэй байна. Уг менежментийн төлбөрийг борлуулалтын орлогын 2 хувиар тооцож байгаа нь охин компанийн санхүүгийн чадвар, ашигт ажиллагаатай уялдаагүй;
- Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК нь толгой компанитай байгуулсан "Менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г дүгнэж, акт үйлдээгүй ба гэрээг байгуулснаас хойш бүртгэсэн 10,826.6 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулах боломжгүй хуримтлагдсан;
- Насжилт ихтэй өр төлбөрийг барагдуулаагүй, барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй /Эрдэнэс Тавантолгой ХК 2,817.8 сая төгрөг, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК 9.4 сая төгрөг, Мон-Атом ТӨХХК 2.6 сая төгрөг/.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 34,391,152.0 сая төгрөг болж, өмнөх оноос 4,452,879.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Өмчийн өөрчлөлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	20,461,149.0	20,580,698.8	119,549.8
Хуримтлагдсан үр дүн	8,880,869.5	13,076,678.0	4,195,808.5
Өмнөх үеийн үр дүн	4,112,933.3	4,184,860.1	71,926.8
Тайлант үеийн үр дүн	4,767,936.2	8,891,817.9	4,123,881.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	595,590.6	733,111.3	137,520.7
Хяналтын бус хувь оролцоо	663.9	663.9	-
Дүн	29,938,273.0	34,391,152.0	4,452,879.0

Эх сурвалж: АҮЭБС-ын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Тайлант онд 4,452,879.0 сая төгрөгийн өмчийн өөрчлөлт гарсан нь харьяа байгууллагууд 4,123.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан, өмчид 119,549.9 сая төгрөгийн өөрчлөлт гарсантай холбоотой байна.

Тайлант үеийн үр дүн 8,891,817.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1.9 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс 18 харьяа байгууллага нийт 8,931,209.9 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 9 байгууллага 39,392.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тухайлбал:

Ашигтай ажилласан

- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаа зэрэг үзүүлэлтүүдтэй байж, орлого нэмэгдэж, зардал хэмнэсэнтэй холбоотойгоор нь 4,528,406.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж, өмнөх оноос 28.4 хувиар өссөн;
- Эрдэнэс Монгол ХХК нь 3,493,940.5 сая төгрөгийн ашигтай ажилласан нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2022, 2023 оны төрийн өмчид ногдох ашгийг МУЗГ-ын 2024 оны 45, 46, 47 дугаар тогтоол, Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 578,528.5 сая төгрөгийн ашигтай ажилласан ч өмнөх оноос 28.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна;
- Эрдэнэс алт ресурс ХХК-ийн борлуулалт нэмэгдсэнтэй холбоотойгоор 163,320.1 сая төгрөгийн ашигтай ажиллаж, өмнөх оноос 21.9 хувиар өссөн.

Алдагдалтай ажилласан

- Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК нь зээлийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулж байгаатай холбоотойгоор 18,470.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
- Шивээ Овоо ХК нь 14,269.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, өмнөх оноос 29.3 хувиар нэмэгдсэн;
- Эрдэнэс Монгол ХХК-аас зээлийн нэгдлийн нэгдсэн стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулах, охин болон хараат компанийн санхүүгийн чадамжийг дээшлүүлэх, компанийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах зорилгоор 2016 оноос өнөөг хүртэл 11.0-14.0 хувийн хүүтэй, 1-2 жилийн хугацаатай зээлийн санхүүжилтийг олгож байгаатай холбоотой Эрдэнэс ҮТП ХХК 1,988.9 сая төгрөгийн, Мон-Атом ТӨХХК 1,873.5 сая төгрөгийн, Эрдэнэс Ашид ХХК 899.0 сая төгрөгийн, Эрдэнэс Газ төсөл 848.6 сая төгрөгийн, Эрдэнэс Метан ХХК 836.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.

Төрийн аудитын байгууллагын өмнөх аудитөөр өгсөн зөвлөмжийн дагуу Багануур сувилал ХХК, Эрдэнэс Ашид ХХК, Эрдэнэс газ төсөл, Монголиан смейлтинг корпорэйшн ХХК, Эрдэнэт медиал эмнэлэг зэрэг байгууллагуудын санхүүгийн тайланг сайдын санхүүгийн тайланд нэтгэж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын бүтцийн өөрчлөлт хийгдэн Цөмийн энергийн комиссын ажлын алба шилжин ирсэн зэрэгтэй холбоотойгоор өмч 37,885.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэлийг ирүүлсэн байна.

3.5.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 163,498.0 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2,184.9 сая төгрөг, зарлагыг 165,682.9 сая төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, хөрөнгийн зардлыг 29,404.2 сая төгрөгөөр, урсгал зардлыг 816.3 сая төгрөгөөр бууруулж, МУЗГ-ын 2021 оны 74 дүгээр тогтоолын дагуу газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг урьдчилан бүрдүүлэхэд шаардлагатай зардлыг улсын төсөвт тусгахаар заасны дагуу 75,532.5 сая төгрөгөөр төсөвлөснийг хасаж, төсвийг 59,929.9 сая төгрөгөөр баталсан байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагууд улсын төсөвт 356,101.5 төгрөгийн орлого бүрдүүлж, төвлөрүүлэхээр баталсан байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд орсон 1 удаагийн өөрчлөлтөөр зарлагын төсвийг 1,864.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 61,794.3 сая төгрөгөөр баталсан байна. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалингийн төсвийг 1,210.0 сая төгрөгөөр, бусад зардлыг 654.5 сая төгрөгөөр нэмсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд 2024 онд улсын төсөвт 326,346.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төсөвлөн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлснийг 29,754.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 356,101.5 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсөвт 321,961.7 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөө 90.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 10. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/					
№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл (хувь)
1	Газрын тосны орлого	284,916.7	237,846.2	(47,070.5)	83.5
2	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	29,626.4	41,565.2	11,938.8	140.3
3	Өөрийн орлого (Сонгон шалгаруулалт)	36,000.0	35,299.2	(700.8)	98.1

4	Үйлчилгээний орлого /газрын тос/	2,744.0	3,018.5	274.5	110.0
5	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2,684.5	3,943.4	1,259.0	146.9
6	Үйлчилгээний орлого /архив лавлагаа/	130.0	289.3	159.3	222.5
Нийт дүн		356,101.5	321,961.7	(34,139.8)	90.4

Үүнээс газрын тосны орлого 16.5 хувиар буюу 47,070.5 сая төгрөгөөр тасарсан нь гэрээлэгч компаниудаас 10, 11 дүгээр сарын орлого 36,650.7 сая төгрөгийг 2025 оны 01 дүгээр сард төвлөрүүлсэн, мөн АМГТГ-аас тооцож хүргүүлсэн төсвийн төслийг Сангийн яамнаас нэмэгдүүлэн баталсантай тус тус холбоотой байна.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 40.3 хувиар буюу 11,938.8 сая төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд шинээр хайгуулын 96, ашиглалтын 55 тусгай зөвшөөрөл олгож, 288 тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр 46.9 хувиар буюу 1,259.0 сая төгрөгөөр давж биелсэн нь тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжин, төлөвлөснөөс 18 компани гэрээний дагуу төлбөрөө төлсөнтэй холбоотой байна.

УГА нь 2024 онд улсын төсөвт 110.0 сая төгрөгийн геологи, эрдэс баялгийн мэдээлэл технологийн, архив лавлагааны орлого төвлөрүүлэхээр төсвийн төслийг тооцон дээд шатны төсөв захирагчид хүргүүлснийг 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 120.2 сая төгрөгөөр баталсан байна.

Үйлчилгээний орлого /архив лавлагаа/-ын гүйцэтгэл 289.3 төгрөг буюу 122.5 хувиар давж биелсэн нь тухайн орлогын онцлог, өмнөх оны гүйцэтгэл зэрэгтэй уялдуулж бодитой төлөвлөж батлуулаагүйтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Улсын төсвөөс 57,345.5 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 5,018.3 сая төгрөгийг бүрдүүлэн, 59,234.7 сая төгрөгийг зарцуулан 3,129.1 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 59,234.7 сая төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн төсвийг 1,414.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 672.4 сая төгрөг, геологи хайгуул, судалгааны төсвийг 288.7, олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамжийн төсвийг 126.1 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	70905 Олборлолт, уул уурхай	60,254.2	57,841.4	(2,412.8)	96.0
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	13,834.3	13,161.9	(672.4)	95.1
2	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	156.6	154.2	(2.4)	98.5


3	80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	126.9	126.9	-	100.0
4	80219 Харуул, хамгаалалтын зардал	102.9	98.0	(4.9)	95.2
5	80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4.2	4.2	-	100.0
6	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	862.3	862.3	-	100.0
7	80239 Тээврийн үйлчилгээ	36.3	36.2	(0.1)	99.7
8	80227 Лабораторийн итгэмжлэл	1.2	1.2	-	100.0
9	80704 Ахмад дайчин, алдар цолтой ахмад	234.3	232.4	(1.9)	99.2
10	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	217.9	217.2	(0.7)	99.7
11	80809 Эмчилгээний төлбөр	26.2	26.2	-	100.0
12	80914 Геологи хайгуул, судалгаа	40,000.0	39,711.3	(288.7)	99.3
13	81706 Химийн хорт бодисыг хоргүйжүүлэх арга хэмжээ	9.8	8.0	(1.8)	81.6
14	81820 Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, дэмжлэг	2,184.9	770.4	(1,414.5)	35.3
15	82401 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	481.1	479.7	(1.4)	99.7
16	82410 Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө	1,975.3	1,951.3	(24.0)	98.8
II	71805 Шинжлэх ухаан, технологи	1,540.1	1,393.3	(146.8)	90.5
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,185.0	1,164.3	(20.7)	98.3
2	80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	40.0	40.0	-	100.0
3	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	72.5	72.5	-	100.0
4	80509 ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	238.9	112.8	(126.1)	47.2
5	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	3.7	3.7	-	100.0
Нийт дүн		61,794.3	59,234.7	(2,559.6)	95.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Тухайн жилийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/344 дүгээр тушаалаар улсын төсвөөр нийт 31,548.3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар баталж, 2024 оны А/78, А/86 дугаар тушаалаар 1,100.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн шинэчлэн баталсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд харьяа 4 агентлагийн урсгал болон хөрөнгийн төсвөөс нийт 32,648.7 сая төгрөгийн 58 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөснөөс 31,231.1 сая төгрөгийн 6 худалдан авалтад нээлттэй, 875.7 сая төгрөгийн 16 худалдан авалтад харьцуулалтын сонгон шалгаруулалт зохион байгуулахаар, 428.3 сая төгрөгийн 30 худалдан авалтыг шууд гэрээ байгуулахаар, 113.7 сая төгрөгийн 6 худалдан авалтад ерөнхий гэрээ байгуулахаар тус тус баталжээ.



Гүйцэтгэлээр 32,112.0 сая төгрөгийн 49 бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж, худалдан авах ажиллагааны тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

Төрийн болон төрийн өмчит хуулийн этгээдийн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс шалтгаалан ТӨБЗГ, холбогдох компаниудын ТУЗ-өөс баталдаг бөгөөд тайлант онд 16 хуулийн этгээдэд нийт 4,147,101.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэл 65.4 хувь буюу 2,711,437.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн 60.2 хувийг Эрдэнэс Тавантолгой ХК, 23.2 хувийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, 11.0 хувийг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК, 1.2 хувийг Багануур ХК, 1.1 Эрдэнэс Монгол ХХК, 1.0 хувийг бусад Шивээ Овоо ХК, 2.3 хувийг бусад байгууллагуудын дүн эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааны хууль, журам мөрдөөгүй 12 байгууллага нийт 22,813.3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан /Шивээ Овоо ХК 7,883.5 сая төгрөг, Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК 7,381.9 сая төгрөг, Эрдэнэс Алт ресурс ХХК 5,587.7 сая төгрөг, Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ 2,239.3 сая төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК 860.7 сая төгрөг, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК 337.7 сая төгрөг, УГА 283.2 сая төгрөг, АҮЭБЯ 257.7 сая төгрөг, АМГТГ 122.0 сая төгрөг/;
- Гэрээний хэрэгжилтийг хангаагүй, хугацаанд нь ашиглалтад оруулаагүй 5 байгууллага 14,611.4 сая төгрөг /Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ 11,732.7 сая төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК 1,690.2 сая төгрөг, УГА 1,124.5 сая төгрөг/;
- Эрдэнэс Оюу толгой ХХК 8,247.0 сая төгрөгийн гэрээт ажлын 70 хувь буюу 5,772.9 сая төгрөгийн урьдчилгааг гүйцэтгэгч компанийн дансанд шилжүүлсэн боловч одоог хүртэл барилгыг хүлээн аваагүй, гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг хангуулаагүйгээс оффисын түрээсийн үргүй зардал гаргасан;
- Эрдэнэс алт ресурс ХХК ажлын гүйцэтгэл гараагүй байхад туслан гүйцэтгэгч нарт нийт 2,880.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон;
- Монголросцветмет ТӨҮГ Тендер сонгон шалгаруулахгүйгээр нэр бүхий компанитай вагон түрээсийн гэрээ байгуулж, урьдчилан 24,096.8 сая төгрөг, гэрээний биелэлт хангагдаагүй 20,773.5 сая төгрөгийн авлагатай байхад 2024 оны 2,3 дугаар сард нэмж 100 вагоны түрээсийн төлбөрт 5,767.7 сая төгрөг төлсөн, нийлүүлэгч талд давуу байдал олгосон.

3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тайлант онд хэрэгжүүлэх уул уурхайн олборлолтын 6 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн хүрээнд 15 шалгуур, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр 1 арга хэмжээ хэрэгжээгүй, 5 арга хэмжээ 54.0-89.4 хувь, 2 арга хэмжээ 94.1-98.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан бол 7 арга хэмжээг 2.2 хувиас 4.0 дахин давуулан биелүүлсэн байна.

Дараах арга хэмжээг төлөвлөснөөс давуулан биелүүлж, хэрэгжүүлсэн. Үүнд:

- Нийт 80 аж ахуйн нэгжийн уулын ажлын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийхээс тайлант онд 30 удаа албан томилолтоор ажиллаж, давтагдсан тоогоор 320 уурхайн үйл ажиллагаатай танилцах, уурхайн баяжуулах үйлдвэр хүлээн авах улсын комисс, хяналт шалгалт хийсэн;

- Ашигт малтмалын хэтийн төлөвтэй 30.0 мянган м.кв талбайн үр дүнг хүлээн авахаас нийт 53.9 мянган м.кв талбайг хамарсан төслүүдийн үр дүнгийн тайланг хүлээн авч, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар орж хамгаалагдсан;
- Тайлант онд 60.0 сая тонн нүүрс экспортлохоос 83.8 сая тонн нүүрс экспортолж, 139.6 хувийн гүйцэтгэлтэй,
- Мөн 1.5 саяас дээш тонн зэсийн баяжмал экспортлохоос гүйцэтгэл 1.7 сая тонн байна.

Зорилтот түвшиндээ хүрээгүй дараах хөтөлбөрүүд байна. Тухайлбал:


- Алт тушаалтын хэмжээг 20-оос дээш тонн байхаас 10.8 тонн алт тушааж, хэрэгжилт 54.0 хувьтай байгаа нь зарим хуулийн этгээд хуулийн хязгаарлалтад орсон, орон нутаг, иргэний хөдөлгөөний улмаас үйл ажиллагаа нь зогссон, ТЭЗҮ батлуулаагүй, тодотгол хийгдэж байгаа, хөрөнгө оруулалтгүй, шүүхийн маргаантай гэх зэрэг шалтгааны улмаас төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй;
- Тайлант онд 270 уулын ажлын тайлангийн хяналт, зөвшөөрөл олгох ажлыг гүйцэтгэхээс ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах үйлдвэрүүдээс уулын ажлын 291 тайлан ирүүлснээс 211 тайлан хянаж баталгаажуулсан;
- Хувийн хөрөнгөөр хийсэн 870 геологи, хайгуулын ажлын тайланг хүлээн авахаас 720-ыг хүлээн авч гүйцэтгэл 82.8 хувьтай байгаа нь тайлант онд 1052 тайлан хянагдаж, 720 тайлан баталгаажуулсан бөгөөд 189 тайлан засварт буцаагдсан, 1 тайлан татгалзсан төлөвтэй байгаагаас шалтгаалсан;
- Тайлант онд 4.7 саяас дээш баррель газрын тосны экспортлохоос 4.1 сая баррелийг экспортолж, гүйцэтгэл 87.2 хувьтай байгаа нь хууль, эрх зүйн орчны тогтворгүй байдал, бүтээгдэхүүн хуваах гэрээ болон 2014 онд шинэчлэн батлагдсан Газрын тосны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаас голлон шалтгаалж хөрөнгө оруулалт буурсан, Чойбалсангийн ДЦС-ын өргөтгөлийн туршилтын ашиглалтын хугацаанд эрчим хүчний хангамжийн тогтворгүй байдал үүсэж, олон удаа саатал гарч цахилгаан эрчим хүчний нийлүүлэлт багасаж үйл ажиллагаа доголдсон, төрийн бус байгууллага болон ард иргэдийн жагсаал, цуглаан зэргээс шалтгаалсан;
- Тайлант онд 8.4 саяас дээш тонн төмрийн хүдэр, баяжмал экспортлохоос 7.5 сая тонныг экспортолж, гүйцэтгэл 89.4 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь БНХАУ-ийн гадаадын зах зээлийн тодорхойгүй байдал, зарим хуулийн этгээдийн орон нутаг, иргэний хөдөлгөөнүүд, ТЭЗҮ батлуулаагүй, тодотгол хийгдэж байгаа, хөрөнгө оруулалтгүй зэргээс шалтгаалсан.

Төлөвлөгдсөн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 60 геологи хайгуулын ажлын тайлан хянаж хүлээж авах зорилт хэрэгжээгүй нь зорилт, хүрэх дүнг үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд АҮЭБЯ, АМГТГ, ҮГА-ны нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 833.1 сая төгрөг төвлөрч, 810.6 сая төгрөгийг зарцуулан, 22.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.



Сангийн сайдын 2024 оны 234 дүгээр тушаалын дагуу 494.1 сая төгрөгийн давсан орлого, Өмнөговь аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан Нутгийн дэм хөтөлбөрийн хүрээнд орон нутагт ажиллаж буй албан хаагчид дамжуулан олгох 31.4 сая төгрөг, архивын ажилтны цалин 16.2 сая төгрөг, Франц-Монголын хамтарсан төслийн хүрээнд 101.2 сая төгрөг, Польш-Монголын хамтарсан төслийн хүрээнд 155.3 сая төгрөгийн, Юнескогийн хамтарсан ажлын хэсгийн 51.2 сая төгрөгийн нийт 833.1 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

Нийт зардлаас 330.9 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний хураамжийн зардалд, 303.1 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд, 136.6 сая төгрөгийн эд хогшил, урсгал засварын зардалд, 39.9 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг иж бүрэн нэгтгэх, санхүүгийн тайлангийн тодруулгыг үнэн зөв тайлагнах, сургалтын урамшууллын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01/335 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,242,627.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 62,426.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт


Төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагчаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар өмнөх онд гаргасан бодлого чиглэлээ баримтлан ажиллаж байгаа бөгөөд 2024 онд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Харьяа байгууллагууд

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн гэж тайлагнасан байна. Тухайлбал:

- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газраас "Төрийн хэмнэлтийн тухай хууль болон компанийн нээлттэй, ил тод байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, журмын хэрэгжилт"-д дотоод хяналт



шалгалт хийсэн, улирал бүр төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаж, хэмнэлт, хэтрэлтийн шалтгааныг тодруулж, гүйцэтгэх удирдлагад танилцуулан, зохих арга хэмжээг авч ажилласан;

- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь цахилгаан, эрчим хүчийг 3 тарифт системээр зохицуулалт хийн 15.1 сая кВт.цаг болгон 3,307.6 сая төгрөг, зарим нормчлогдсон материалын үйлдвэрлэлийн тоо хэмжээг бууруулан 41,300.5 сая төгрөг, цалингийн зардлаас 18,214.1 сая төгрөгийг тус тус хэмнэсэн;
- Багануур ХК нь Төрийн хэмнэлтийн тухай хууль түүнтэй холбогдон гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгөхөөр 14 асуудлын зөвлөмжийг 93.0 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэн ажилласан;
- Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ цахилгааны РП-4 под станцыг иж бүрнээр нь шинэчилснээр сард төлдөг цахилгааны зардлыг дунджаар 6.0 сая төгрөгөөр, хүйтэн усны хэвтээ магистрал шугам, дулааны хаалт зэргийг сольж шинэчилснээр цэвэр усны алдагдлыг бууруулж, сард төлдөг цэвэр усны зардлыг 2 сая орчим төгрөгөөр, бүтцийн өөрчлөлтөөр 2 хэлтсийг нэгтгэснээр 1 хэлтсийн даргын орон тоо хэмнэгдэж, 30.0 орчим сая төгрөгийн цалингийн зардал хэмнэсэн;
- Монголросцветмет ТӨҮГ нь үйлдвэрийн газрын Захирлын 2022 оны А/226 тоот тушаалаар баталсан хэмнэлтийн горимыг мөрдөн ажиллаж байна;
- Тавантолгой төмөр зам ХХК орлого нэмэгдүүлж, зардал бууруулах төлөвлөгөөг боловсруулан ажилласан. Орлого нэмэгдүүлэх төлөвлөгөөний хүрээнд нэг түвшний гарам ашиглуулах, зам хэмжигч болон сэв шалгагч вагоныг түрээсээр ажиллуулах, машин механизмын түрээсийн үйл ажиллагааны орлого, ачааны вагоны түрээсийн орлого, бусдын эзэмшлийн вагонд үзлэг засвар хийх үйлчилгээний орлого, авто зам ашиглуулсны орлогыг 1,427.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөснөөс 1,999.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн;
- Шивээ Овоо ХК, Эрчис ойл ХХК нь орон тоог хэтрүүлэхгүй байх, хууль тогтоомжид зааснаас өөр шагнал урамшуулал олгоогүй, бичиг хэрэг хөтлөлтийг дотоод сүлжээ, цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хувилагчийн хорны болон тээврийн хэрэгслийн ашиглалт, шатахууны зардлыг хэмнэх, байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр усыг тоолууржуулах, цахилгаан хэрэгслийг техникийн тодорхойлолтын дагуу ашиглах зэрэг арга хэмжээ авч ажилласан;
- Эрдэнэс Монгол ХХК нь албан хэрэг хөтлөлт, хурал зөвлөгөөн, сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх, зайлшгүй шаардлагатайгаас бусад засвар үйлчилгээ, хангамжийн зардлыг бууруулах арга хэмжээ авсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн зөрчил

Харьяа байгууллагуудад нийцлийн асуудлаар нийт 1,221,913.8 сая төгрөгийн 70 зөрчил илэрч, 2.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 282,670.9 сая төгрөгийн зөрчилд 24 албан шаардлага, 908,160.6 сая төгрөгийн зөрчилд 40 зөвлөмж, хариуцлага тооцуулахаар 31,079.5 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийцлийн бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 2 зөрчил илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

Түүвэр хамрагдсан Эрдэнэс ҮТП ХХК, Эрдэнэс Ашид ХХК-д компанийн урт, дунд хугацааны бодлогыг боловсруулан мөрдөж, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар нийт 2 зөвлөмж хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 18 байгууллага Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүйгээс нийт 117,786.8 сая төгрөгийн зөрчил илэрч, 117,717.2 сая төгрөгийн 10 албан шаардлага, 69.5 сая төгрөгийн 9 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид тус зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төвлөрч буй сургалтын урамшууллын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах асуудлын талаар

Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгчээс бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгөөр сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг 2020 оноос өнөөг хүртэл хийгээгүй, тус салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх нөөц боломжийг алдагдуулсан байна.

Тайлант онд сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах суралцагчдын сонгон шалгаруулалтыг зарлах, бүртгэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааг МУЗГ-ын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан журмаар зохион байгуулахаар болсон боловч хэрэгжилт хангагдаагүй, сургалтын урамшууллын зардлын 2,186.2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Энэ нь МУЗГ-ын 2024 оны 102 дугаар тогтоолоор баталсан "Сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах суралцагчдыг сонгон шалгаруулалтыг зарлах, бүртгэх, сонгон шалгаруулах үйл ажиллагааны журам"-ын 11.8. "Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ЗГХЭГ, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага, төрийн өмчийн их, дээд сургууль, сан, төрийн бус болон мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгчээс бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгөөр сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2. Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хугацаа хоцроон ирүүлсэн талаар

ТЕЗ-ийн харьяа 5 байгууллага /АҮЭБС, АҮЭБЯ, Шивээ Овоо ХК, Эрчис Ойл ХХК, Цөмийн энергийн комисс/-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хугацаа хоцроон ирүүлсэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлж байх, харьяа байгууллагад хяналт хэрэгжүүлэх.

Түүвэрт хамрагдсан байгууллагуудад илэрсэн зөрчил

Зөвлөмж

Эрдэнэс ҮТП ХХК-д

Илрүүлэлт: Компанийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй, тайлант онд стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар төлөвлөснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 70 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3 "Компанийн ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэн, хувьцаа эзэмшигчийн үр өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг өсгөхийг эрмэлзэнэ", 1.3.3.Компани хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлагын талаар аливаа шийдвэр гаргахдаа тухай хөрөнгө оруулалтын эдийн засаг, санхүүгийн үр өгөөж, тооцоо судалгаанд үндэслэсэн байна", 3.3 "Гүйцэтгэх удирдлага. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 115 дугаар тогтоолоор баталсан Бизнес төлөвлөгөө-тэй тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулж, мөрдөх.

Эрдэнэс Ашид ХХК-д

Илрүүлэлт: Компанийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй байна. Тайлант онд дунд хугацааны буюу 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар төлөвлөн, хэрэгжилтийг 40 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Энэ нь Эрдэнэс Ашид ХХК-ийн ХЭХ-ын 2024 оны 6 дугаар тогтоолоор баталсан компанийн дүрмийн 3.2. "Хувьцаа эзэмшигчдийн хурал. 3.2.5.1.Нэгдлийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлах", 3.4. "Гүйцэтгэх удирдлага. 3.4.2.1.компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэл, жил бүрийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан төлөвлөгөө, шийдвэрийг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Компанийн урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулан мөрдөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 22 байгууллагын 430,627.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 1,818.0 сая төгрөгийн 12 төлбөрийн акт тогтоож, 357,937.4 сая төгрөгийн зөрчилд 79 албан шаардлага хүргүүлж, 60,760.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 118 зөвлөмж өгч, 10,111.8 сая төгрөгийн 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлснийг 85.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Акт	12	1,818.0	12	1,144.4	95.6
2	Албан шаардлага	79	357,937.4	67	346,021.9	84.2
3	Зөвлөмж	118	60,760.0	101	26,098.1	82.7
4	Хууль хяналт	3	10,111.8	3	5,055.9	50.0
Нийт дүн		212	430,627.3	183	378,320.3	85.9

Үүнээс 7 байгууллага 70.0-80.0 хувийн, 9 байгууллага 80.0-90.0 хувийн, 6 байгууллага 90.0-100.0 хувийн хэрэгжилттэй байна.

Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулахаар байгууллага тухай бүрд дараагийн шатны арга хэмжээг авахаар шийдвэрлэсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. Концессын гэрээгээр Рашаант дахь газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах барих төслийн ажлын талаар

МУЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 71-д Рашаант дахь газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулах барих төслийг өмчлөх, ашиглах төрлөөр хэрэгжүүлэхээр баталж, МУЗГ-ын 2015 оны 119 дүгээр тогтоолоор Нэйшнл Трейдинг Энд Транспорт Групп ХХК-тай концессын гэрээг Үндэсний хөгжлийн газар /хуучнаар Хөрөнгө оруулалтын газар/ байгуулсан. Гэвч энэ хугацаанд 3,583.9 сая төгрөгийн хэрэгжилт гарч,

дуусаагүй барилга байгууламжийн дансанд бүртгэлтэй байгаа бөгөөд Үндэсний хөгжлийн газраас гэрээг сунгасаар байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн А/90 дүгээр тушаалаар дээрх гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан байна.

2. Эрдэнэс Монгол ХХК-ийн хөрөнгө оруулалтын талаар

Эрдэнэс Ашид ХХК-ийн дүрмийн сан /төрийн өмч/-ийг нэмэгдүүлэхдээ Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны "Эрдэнэс Ашид ХХК-ийн 2024 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай" 45 дугаар тогтоолыг үндэслэсэн байна. Өөрөөр хэлбэл Эрдэнэс Ашид ХХК-ийн 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 2,055.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 369.0 сая төгрөгийн төсөв баталж, энэ хэмжээгээр Дүрмийн сан буюу төрийн өмчийг нэмэгдүүлсэн байна.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Нийт дүн		Мэдээллийн тусгахгүй орхигдуулсан		Буруу илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Залруулаагүй	
		Тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	2	-			2	-			2	-	2	-
	Дүн /ТЭЗ/	2	-			2	-			2	-	2	-
1	Ашигт малтмал, газрын тосны газар	1	-			1	-			1	-	1	-
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	9	873.4			9	873.4	6	210.2	3	663.2	3	663.2
3	Үндэсний геологийн алба	6	15,330.2			6	15,330.2	4	15,330.2	2	-	2	-
4	Цөмийн энергийн комисс	1	0.9			1	0.9			1	0.9	1	0.9
	Дүн /ТШЗ/	17	16,204.6	-	-	17	16,204.6	10	16,640.4	7	664.1	7	664.1
1	Багануур ХК	7	20,001.4			7	20,001.4	7	20,001.4				
2	Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ	3	1,375.7			3	1,375.7	3	1,375.7				
3	Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК	8	7,987.2			8	7,987.2	8	7,987.2				
4	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ	2	43.9			2	43.9	2	43.9				
5	Мон-Атом ТӨХХК	5	71.9			5	71.9	5	71.9				
6	Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК	4	11,851.1			4	11,851.1	4	11,851.1				
7	Таван толгой төмөр зам ХХК	5	6,316.1			5	6,316.1	5	6,316.1				
8	Шивээ Овоо ХК	1	2,004.6			1	2,004.6	1	2,004.6				
9	Эрдэнэс Монгол ХХК	2	242.8			2	242.8	1	13.1	1	229.7	1	229.7
10	Эрдэнэс алт ресурс ХХК	4	8,675.8			4	8,675.8	4	8,675.8				
11	Эрчис ойл ХХК	2	4,373.4			2	4,373.4	2	4,373.4				
12	Эрдэнэс Тавантолгой ХК	1	429.9			1	429.9			1	429.9	1	429.9

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

13	Эрдэнэс Ашид ХХК	1	10.9			1	10.9			1	10.9	1	10.9
	Дүн /төрийн өмчөт/	45	63,384.7			45	63,384.7	42	62,714.3	3	670.4	3	670.4
	Нийт дүн	64	79,689.3	-	-	64	79,689.3	52	78,264.7	12	1,334.5	12	1,334.5

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	7	477.4			5	477.4	2	-				
	Дүн /ГЕЗ/	7	477.4			5	477.4	2	-	-	-	-	-
1	Ашигт малтмал, газрын тосны газар	10	6,770.8	1	20.5	7	5,750.2	2	-				
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	13	376.8	6	60.8	7	314.8	-	-				
3	Үндэсний геологийн алба	9	3,401.7			4	1,571.8	5	1,829.9				
4	Цөмийн энергийн комисс	1	11.1			1	11.1						
	Дүн /ТШЗ/	33	9,559.1	7	81.3	19	7,647.9	7	1,829.9	-	-	-	-
1	Багануур ХК	11	846.1	1	0.6	3	222.2	5	3.6	2	618.7		
2	Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ	7	446.0	2	4.7	2	7.1	2	7.3	1	445.9		
3	Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК	23	42,207.4	1	2.2	9	15,392.8	13	28,812.7				
4	Шингэн түлш шилжүүлэн авчиг байгууламж ТӨААТҮГ	5	6.1	2	3.2	2	-	1	1.9				
5	Мон-Атом ТӨХХК	2	2.6			1	2.6	1	-				
6	Монголросцветмет ТӨҮГ	10	7,556.5			3	1,035.0	6	753.8			1	5,767.7

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит													
7	Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК	7	590.9	1	1.2	2	585.7	4	3.9				
8	Таван толгой төмөр зам ХХК	19	77,045.3	1	14.4	10	74,236.8	8	2,794.1				
9	Шивээ Овоо ХК	5	594.8	1	2.4	3	892.5	1	-				
10	Эрдэнэс Монгол ХХК	8	12,076.6	1	11.0	8	12,003.5	1	62.1				
11	Эрдэнэс алт ресурс ХХК	5	8,521.8	1	32.9	2	4,360.1	1	2,880.0	1	1,248.8		
12	Эрдэнэс оюу толгой ХХК	6	14.2	1	2.1	2	2.1	3	10.0				
13	Эрдэнэт медицинал эмнэлэг ХХК	8	252.9	3	3.2	4	249.7	1	-				
14	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	14	116,516.6			7	103,097.0	7	13,419.6				
15	Эрдэнэс Тавантолгой ХК	19	38,649.9			10	34,371.3	9	4,498.6				
16	Эрдэнэс Ашид ХХК	4	75.1					4	75.1				
17	Эрдэнэс УТГ ХХК	5	69.7			1	42.0	4	27.5				
Дүн /төрийн өмчит/		158	306,009.5	15	77.9	67	246,500.2	71	51,380.3	4	2,313.4	1	5,767.7
НИЙТ ДҮН		198	316,046.0	22	159.2	91	254,625.5	80	53,180.2	4	2,313.4	1	5,767.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

д/д	Байгууллагын нэр	Нийт дүн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	2	-					2	-		
	Дүн /ТЭЗ/	2	-			-	-			-	-
1	Ашигт малтмал, газрын тосны газар	2	-					2	-		
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	6	282.4			3	151.1	3	131.3		
3	Үндэсний геологийн алба	3	-			1	-	2	-		
4	Цөмийн энергийн комисс	1	-					1	-		
	Дүн /ТШЗ/	12	282.4	-	-	4	151.1	8	131.3	-	-
1	Багануур ХК	2	5,245.1			1	2,647.7			1	2,600.4

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2	Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ	1	-						1	-	
3	Дарханы Төмөрлөгийн үйлдвэр ХХК	10	7,482.3			4	7,015.0	5	70.4	1	387.0
4	Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨААТҮГ	1	50.6					1	50.6		
5	Мон-Атом ТӨХХК	2	60.0			2	60.0				
6	Монголросцветмет ТӨҮГ	2	4,011.7			2	4,011.7				
7	Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ХХК	4	9,736.4			3	9,736.4	1	-		
8	Таван толгой төмөр зам ХХК	1	-					1	-		
9	Шивээ Овоо ХК	3	7,902.4			1	7,883.5	2	18.9		
10	Эрдэнэс Монгол ХХК	2	164,932.4			1	164,932.4	1	-		
11	Эрдэнэс алт ресурс ХХК	1	-					1	-		
12	Эрдэнэс оюу толгой ХХК	1	-							1	-
13	Эрдэнэт медиал эмнэлэг ХХК	7	2.8	1	2.8	1	-	5	-		
14	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	3	28,112.2			2	-			1	28,112.2
15	Эрчис ойл ХХК	1	-					1	-		
16	Эрдэнэс Тавантолгой ХК	15	994,122.5			3	86,233.1	12	907,889.4		
17	Эрдэнэс Ашмд ХХК	1	-					1	-		
18	Эрдэнэс УТП ХХК	1	-					1	-		
Дүн /төрийн өмчит/		58	1,221,631.4	1	2.8	20	282,519.8	32	908,029.3	8	31,079.5
НИЙТ ДҮН		72	1,221,913.8	1	2.8	24	282,670.9	42	908,160.6	5	31,079.5